

**“ДАРХАН ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА ЗАХИАЛАГЧИЙН ГАЗАР”
ОНӨААТҮГ-ЫН 2022 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Төсвийн Ерөнхийлөн захирагч

Төлөвлөгөөг хянасан:
Дархан-уул аймгийн
Засаг дарга
(албан тушаал)

Тэмдэг



/Б.АЗЖАРГАЛ/

2022.03.20

(огноо)

Төсвийн Шууд захирагч

Төлөвлөгөө баталсан:
“Дархан-Хот байгуулалт
барилга захиалагчийн газар”
ОНӨААТҮГ-ын Дарга
(албан тушаал)

Тэмдэг



/Д.БАТБАЯР/

2022.01.05

(огноо)

**“Дархан-Хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ-ын
2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө**

Байгууллагын үйл ажиллагааны **ЭРХЭМ ЗОРИЛГО** нь: Төсөл хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг ханган, хөрөнгө оруулалтын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх.

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа /I-IV улирал/	Хариуцах нэгж
Стратеги төлөвлөгөөний зорилго-1. Барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, шинэчлэн засварлах ажлыг гүйцэтгэх нөхцлийг бүрдүүлж эхлүүлэх, батлагдсан зураг төсөл, стандарт, техникийн нөхцөл болон технологийн хяналт тавьж гүйцэтгэлийг баталгаажуулах, хөрөнгө оруулалт, санхүүгийн эх үүсвэрийг үр ашигтай зарцуулж төлөвлөсөн хугацаанд ашиглалтад оруулах.							
1	Зорилт 1- Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг нийгмийг 2022 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Дархан-уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Дархан-Уул аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол улсын төсвийн хөрөнгөөр 2022 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төсөв /Дархан-Уул аймаг/, аймгийн ИТХ ын төлөөлөгчдийн 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдөр батлагдсан “Аймгийн 2020 оны төсвийн гүйцэтгэл, 2022 оны төсөв батлах тухай” Сумдын ИТХ-ын төлөөлөгчдийн тогтоолоор батлагдсан төсөвт тусгагдсан төсөлд захиалагчийн техникийн шаталсан хяналтыг хэрэгжүүлж гүйцэтгэлийг үе шатны хуваарийн дагуу хянан баталгаажуулах.						
1.1	Барилга угсралт, авто зам, замын байгууламж, инженерийн шугам сүлжээний 92 төсөл хөтөлбөр, арга хэмжээнд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны техникийн хяналт хэрэгжүүлэх.	204,6 тэрбум төгрөгийн өртөг бүхий 92 төсөл хөтөлбөрт захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлнэ. /2022 онд санхүүжих дүн 115,8 тэрбум төг/	-2021-2022 онд үргэлжлэн хэрэгжих 26 төсөл арга хэмжээ -2022 онд шинээр хэрэгжих 64 төсөл арга хэмжээнд буюу нийт 92 төсөл хөтөлбөрт захиалагчийн техникийн өдөр тутмын болон үе шатны хяналт хэрэгжүүлнэ.	Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг нийгмийг 2021 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Дархан-уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 2020-2021 онд шилжин хэрэгжсэн 12 төсөл, арга хэмжээ, 2021 онд шинээр хэрэгжсэн 52,4 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 112 төсөл, арга хэмжээ буюу нийт 124 төсөл, арга хэмжээнд захиалагчийн техникийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан ба үүрэг даалгаврын биелэлтийг 95,6%-иас дээш хангуулан ажлын явцыг 6614 фото зургаар баримтжуулж үе шатны 1086 ажлыг ил далд ажлын актаар баталгаажуулж, гүйцэтгэлийн баримт бичгийн иж бүрдлийг хангуулан, биелэлтийг дүгнэж барилгын ажлын тоо хэмжээг тулган шалгаж санхүүжих гүйцэтгэлийг баталгаажуулсан. Төсвийн зарцуулалтын үр ашигтай байдлыг ханган магадлашгүй ажил болон	2022 онд Дархан-уул аймагт баригдах барилга угсралт, засвар шинэчлэлт, тохижилтын 204,6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 92 төсөл арга хэмжээ хэрэгжинэ. 2021-2022 онд шилжин хэрэгжиж буй төслөөс 2021 онд 18,7 тэрбум төгрөгийн гүйцэтгэл хийгдсэн. 2022 онд 115,8 тэрбум төгрөгийн ажлын гүйцэтгэлийг баталгаажуулна. Дээрх 92 төсөл хөтөлбөрт захиалагчийн шаталсан техник хяналтыг хэрэгжүүлж барилга байгууламжийн норм нормативын баримт бичиг, тухайн барилгын ажлын батлагдсан зураг төсөл болон төсөв, гүйцэтгэгчтэй байгуулсан	2-4 улирал	ИТА

				бусад хийгдээгүй ажлын зардлаас 163,6 сая төгрөгийг хэмнэсэн. • Байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн-99 төсөл, арга хэмжээ • 2021-2022 онд шилжин хэрэгжих төсөл арга хэмжээний тоо-26	гэрээнд тусгасан барилгын ажлын үе шатны хуваарийг төсөл, арга хэмжээ нэг бүрээр нь тулган шалгаж хянан баталгаажуулж барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээлгэн өгөх. 2022 онд шилжин хэрэгжих төсөл • УТХО-49,3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 13 төсөл • ОНТХО -520,9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл • ОНХС-2,0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл • Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо-609,6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл	
--	--	--	--	--	---	--

1.2 БАРИЛГА УГСРАЛТ

Зорилго 1.2 Барилга байгууламж шинээр барих, өргөтгөх шинэчлэн засварлах төсөл арга хэмжээнд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны хяналт хэрэгжүүлж барилгын ажлын үе шатны хуваарийг төсөл, арга хэмжээ нэг бүрээр нь тулган шалгаж хянаж баталгаажуулах.

1.2.1	Нийт 46 төсөл арга хэмжээнд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны хяналт хэрэгжүүлж барилгын ажлын үе шатны хуваарийг төсөл, арга хэмжээ нэг бүрээр нь тулган шалгаж хянаж баталгаажуулах.	Нийт 68,9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 46 төсөл арга хэмжээнд (2022 онд санхүүжих дүн 30,8 тэрбум төгрөг).	-2021-2022 онд үргэлжлэн хэрэгжих 9 төсөл арга хэмжээ -2021 онд шинээр хэрэгжих 37 төсөл арга хэмжээ	Барилга угсралт, засвар шинэчлэлт тохижилтын 24,1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 58 төсөл, арга хэмжээнд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны техникийн хяналт хэрэгжүүлж ажилласан ба 252 зөвлөмж, үүрэг даалгаврыг өгч биелэлтийг 95%-иас дээш хангуулан 89 лабораторийн сорил шинжилгээ хийлгэж ажлын явцыг 2357 фото зургаар баримтжуулж, үе шатны 273 ажлыг ил далд ажлын актаар баталгаажуулсан. Гүйцэтгэгч байгууллагуудын гүйцэтгэлийн баримт бичгийн иж бүрдлийг хангуулан, биелэлтийг дүгнэн барилгын ажлын тоо хэмжээг тулган шалгаж 63 санхүүжилтийн гүйцэтгэлийг хянан баталгаажуулсан.	Барилга угсралт, засвар шинэчлэлт, тохижилтын 46 төсөл/ -Зураг төслийг судалж дүн шинжилгээ хийх. -Ажил эхлэх объект тус бүр дээр хувийн хэрэг нээж өдөр тутмын мэдээллээр баяжуулан хөтлөх. -Үе шатны ажил бүрийг хэмжин шалгаж хүлээж авах, хэрэглэгдсэн материал, хийц бүтээцийн лабораторийн шинжилгээний сорил авч актаар баталгаажуулах. - Дараагийн үе шатны ажлын зөвшөөрлийг олгох. -Гүйцэтгэлийг батлагдсан төсвийн дагуу хянаж санхүүжүүлэх.	2-4 улирал	Барилгын инженер
-------	--	--	---	--	--	------------	------------------

1.3 ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭ

1.3.1 ЦЭВЭР УС, ДУЛААН ХАНГАМЖ, БОХИР УС ТАТАН ЗАЙЛУУЛАХ

Зорилго 1.3.1 Инженерийн шугам сүлжээ шинээр барих, өргөтгөх, шинэчлэн засварлах үйл ажиллагаанд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны техникийн хяналтыг хэрэгжүүлж барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг баталгаажуулж хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэн байнгын ашиглалтад оруулах.

"Барилга байгууламж шинээр барих, өргөтгөх шинэчлэн засварлах төсөл арга хэмжээнд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны хяналт хэрэгжүүлж барилгын ажлын тоо хэмжээ, төсөв гүйцэтгэлийг төсөл, арга хэмжээ нэг бүрээр нь тулган шалгаж хянан баталгаажуулах"							
1.5.1	Барилга угсралт, авто зам, замын байгууламж, инженерийн шугам сүлжээний 90 төсөл, арган хэмжээнд төсвийн хяналт хийж баталгаажуулах.	204,6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 90 төсөл арга хэмжээ /2022 онд санхүүжих дүн 115,8 тэрбум төгрөг/	2022 онд санхүүжих 204,6 тэрбум төгрөгийн өртөг бүхий 90 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн төсөвт хяналт хийж баталгаажуулах	2020-2021 онд шилжин хэрэгжсэн 12 төсөл, арга хэмжээ, 2021 онд шинээр хэрэгжүүлсэн 112 төсөл арга хэмжээнд захиалагчийн техник хяналт хэрэгжүүлж ажилласан ба барилгын ажлын үе шатны хуваарийг төсөл, арга хэмжээ нэг бүрээр нь тулган шалгаж 32,0 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийг баталгаажуулсан. Төсвийн зарцуулалтын үр ашигтай байдлыг ханган магадлашгүй ажил болон бусад хийгдээгүй ажлын зардлаас 163,6 сая төгрөгийг хэмнэлт үүсгэж ажилласан.	Төсвийн зарцуулалтын үр ашигтай байдлыг хангана.	2-4 улирал	Төсөвчин
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО 2- Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх.							
2.1 Хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах, газрын сургалтын төлөвлөгөөний дагуу сургалт зохион байгуулж ажилчдын мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх.							
2.1.1	Хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах.		Хамт олны багаар ажиллах болон мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх.	Байгууллагын ИТА албан хаагчдыг ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ажлын байр, тоног төхөөрөмж, бичиг хэрэг, автомашин, багаж хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын хувцас, хоол унааны мөнгө, сар бүр ур чадварын нэмэгдэл зэргийг олгож ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэж ажиллалаа. 2021 оны батлагдсан бүтэц орон тооны хязгаарт багтаан үндсэн 8 гэрээгээр 4 инженер ажилд аван нийт 12 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явууллаа. Бүтээн байгуулалтын ажилд багаар ажиллах, өөрчлөлтийг хүлээж авах, оновчтой шийдвэр гаргах мэргэжлийн ур чадвартай мэргэшсэн инженерүүдийг томилон ажиллуулж байна. Газрын дарга нь инженер техникийн ажилтан, албан хаагчдын сар бүрийн ажлын явц, тайлангийн биелэлтийг хянан баталгаажуулж ур чадварын нэмэгдлийг олгосон. Байгууллагын ёс зүйн дүрмийг шинээр батлан мөрдүүлж ажилласан ба ажилтан бүртэй хөдөлмөрийн гэрээг шинээр байгуулж ажилласан. Ажилчидтай 2021 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулсан ба ажлын үр дүнг сар бүрийн тайлангийн биелэлт, ажлын гүйцэтгэлийг харгалзан үзэж ур чадварын нэмэгдэлд 12 сая төгрөг, хоол унааны хөнгөлөлтөд 5.9 сая төгрөгийн нэмэгдлийг олгосон.	Хамт олныг удирдан зохион байгуулах, багаар ажиллах, өөрчлөлтийг хүлээж авах, оновчтой шийдвэр гаргах, мэргэжлийн ур чадвартай инженер техникийн ажилтан, албан хаагчид бүхий хамт олныг бүрдүүлсэн байна.	1-4 улирал	Байгууллагын удирдлага

2.1.2	Сургалтын хэрэгцээг тодорхойлж төлөвлөгөө боловсруулан, төлөвлөгөөний дагуу сургалтанд хамрагдах, сургалт зохион байгуулах.	Сургалтын зардал	Газрын сургалтын төлөвлөгөөний дагуу инженер техникийн ажилтан, албан хаагчдыг сургалтанд хамруулж мэдлэг мэргэшлийг дээшлүүлэх.	2021 оны байгууллагын батлагдсан сургалтын төлөвлөгөөний дагуу Барилгын инженер Б.Анхбаяр нь Барилгын хөгжлийн төвөөс зохион байгуулж буй "Мэргэшсэн инженер" ийн 10 кредит багц цагийн сургалтад 14 хоног цахимаар хамрагдсан. Сантехникийн инженер Б.Гантуяа нь 2020 онд "Мэргэшсэн инженер"-ийн багц цагийн сургалтад 100% хамрагдсан. Бичиг хэргийн ажилтан А.Нарангарав нь Архивын ерөнхий газраас зохион байгуулсан "Архив-албан хэрэг хөтлөлт"-ийн сургалтад цахимаар хамрагдсан. Авто замын инженер Д.Аюурзана нь Үндэсний Дата төвөөс зохион байгуулсан Вэб админ, вэб хуудас хөгжүүлэх сургалтад хамрагдсан. Мөн авто замын хяналтын инженерийн сургалтад хамрагдсан. Мөн ИТА, албан хаагчид нь ерөнхий инженерийн удирдлагаар "Нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль", Авилгын тухай хуулийн талаар танилцуулга болон "Барилгын зураг төсөл, угсралт, материал, технологи"-ийн шинэ мэдээллүүдээр хийсэн сургалтад хамрагдаж мэдлэг, мэргэшил үр чадвараа дээшлүүлсэн.	Байгууллагын сургалтын төлөвлөгөөний дагуу инженер техникийн ажилтан, албан хаагчдыг мэргэжлийн сургалтанд хамруулсан байна.	1-4 улирал	Байгууллагын удирдлага, ерөнхий инженер
2.2 Мэдээ тайлан гаргах, мэдээллийн сан бүрдүүлэх, хэрэглэгчдийг мэдээллээр хангах.							
2.2.1	Мэдээ тайлан гаргаж, мэдээллийн сан бүрдүүлэх	Төсөв шаардагд ахгүй.	Барилга угсралтын явцын мэдээ тайланг тогтмол гаргаж газрын удирдлага болон холбогдох байгууллагуудад хүргүүлэх. Мөн төсөл арга хэмжээ бүрээр мэдээллийн сан бүрдүүлэх.	2020 оны гүйцэтгэлийн тайлан, 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулан аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-т хүргүүлсэн. 2020 оны байгууллагын жилийн эцсийн тайланг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчид болон аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд 2021 оны 02 дугаар сард танилцуулсан. Санхүүгийн ил тод байдлын мэдээг shilendans.gov.mn сайтад сар бүр гаргаж олон нийтэд мэдээлсэн. Мөн 2020 санхүүгийн тайланг гарган ЦЭСБ аудитаар баталгаажуулан холбогдох байгууллагуудад хугацаанд нь хүргүүлсэн. 2021 оны жилийн эцсийн байдлаар 347 ш архивын хадгаламжийн нэгж газрын архивт хадгалагдаж байгаа ба 2020 оны жилийн эцсийн мэдээг аймгийн Архивын тасагт хүргүүлсэн.	Төсөл бүрээр мэдээллийн санг бүрдүүлж, өдөр тутмын мэдээллээр баяжуулж хувийн хэрэг үүсгэнэ. Мэдээ тайланг холбогдох байгууллагуудад хугацаанд нь хүргүүлнэ.	1-4 р улирал	ИТА, албан хаагчид

2.2.2	Холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангах.	Төсөв шаардагд ахгүй.	Аймаг орон нутгийн удирдлага болон холбогдох байгууллагуудыг барилга угсралтын төсөл хөтөлбөр, арга хэмжээний явцын тухай мэдээллээр хангаж ажиллах.	Дархан-Уул аймгийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын мэдээллийг Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-т долоо хоног бүр буюу 2021 онд 34 удаа тайлагнасан. Аймгийн Мэдээлэл, технологийн албанаас эрхлэн явуулдаг “Дарханы мэдээ” цахим хуудастай хамтран ажиллаж улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй томоохон төсөл арга хэмжээний явцын талаар олон нийтэд ил тод, нээлттэй мэдээлсэн. 2021 онд байгууллага, иргэдээс ирүүлсэн нийт 408 албан бичиг хүлээн авч бүртгэн хариутай бичгийг 100% хугацаанд нь шийдвэрлэсэн. 509 албан бичгийг холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажиллалаа. Барилга угсралт, засвар шинэчлэлт өргөтгөлийн 124 төсөл, арга хэмжээ бүрээр объектын тайлан гаргаж газрын мэдээллийн санг бүрдүүлж ажилласан ба тайланг хагас болон бүтэн жилээр гарган аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-т хүргүүлэн ажилласан.	Аймаг орон нутгийн удирдлага болон холбогдох байгууллагуудыг барилга угсралтын төсөл хөтөлбөр, арга хэмжээний явцын тухай мэдээллээр хангаж ажиллах.	2-4 р улирал	ИТА ажилтан, албан хаагчид
2.3 Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах.							
2.3.1	Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах.	Үйл ажиллагааны зардлаас санхүүжүүл нэ.	Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах: “Дархан-Хот байгуулалт барилга захиалагчийн газар” цахим хуудсаар дамжуулан олон нийтэд барилгын ажлын явцын талаар мэдээ мэдээлэл тавих.	Аймгийн Мэдээлэл технологийн албатай 2021 оны 06 дугаар сарын 05 нд “Хамтран ажиллах гэрээ”-г байгуулсан. Гэрээт хугацаанд улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн, хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэлийн хяналтын талаар фото болон дүрст мэдээ, сурвалжилга, шууд дамжуулалт нийт 45-ыг бэлтгэн цахим сүлжээн дэх албан ёсны фэйсбүүк, фэйж хуудсууд /Дархан-Уул аймаг, Дархан хот, Дархан-Уул аймгийн Засаг даргын тамгын газар/ орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагуудаар дамжуулан олон нийтэд түгээн ажилласан байна. Байгууллагын da.barilga.gov.mn вэб хуудас, Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар цахим хуудсаар мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргүүлэн ажиллалаа. Байгууллагын фэйсбүүк хуудаст байршуулсан барилга угсралтын төсөл, арга хэмжээний мэдээ, мэдээллийг давхардсан тоогоор 63943 хүн харсан ба 1001 хүн дэмжин, 1021 хүн дагасан үзүүлэлттэй байна. 2021 оны 10 дугаар сарын 17 ны өдөр буюу Дархан хотын 60 жилийн ойн өдрөөр Дархан сумын 14 дүгээр баг, Миний монгол цэцэрлэгт хүрээлэнд шинээр баригдсан “Алсыг харагч” тоглоомыг нээх үйл ажиллагааг зохион байгуулж хүүхэд залуучуудын дарааллын журмыг баримтлуулан халдвар хамгааллын дэглэмийг сахиулах үүднээс хүүхэд, багачуудад нэг удаагийн амны хаалт тарааж, гарыг ариутган тоглоом руу оруулж үйлчиллээ.	Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулсан байна. Аймгийн Мэдээлэл технологийн албатай хамтран ажиллах.	1-4 р улирал	ИТА, албан хаагчид

2.4 Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах.							
2.4.1	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах.		Холбогдох хууль, тогтоол, дүрэм, журмыг баримтлан Газрын дарга нь тушаал шийдвэр гаргах ба ажилчид үүрэг даалгаврыг биелүүлж, хэрэгжилтийг хангуулж ажиллах	Холбогдох хууль тогтоомж тушаал шийдвэрийн хэрэгжилтийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллалаа. Аймгийн засаг Дарга, сумдын Засаг дарга нартай гэрээ байгуулсан нийт 124 төсөл, арга хэмжээнд захиалагчийн техникийн өдөр тутмын болон үе шатны хяналтыг хэрэгжүүлж ажилласан. Хууль тогтоомжийг үндэслэл болгон Даргын А тушаал 96 ш, Б тушаал 31 ш гарган мөрдөж ажилласан. Газрын хэмжээнд ажилчдаас ирүүлсэн 17ш өргөдлийг бүртгэн газрын Даргад танилцуулж хугацаанд нь шийдвэрлэсэн.	Холбогдох хууль, тогтоол, тушаал шийдвэр, дүрэм журмыг мөрдлөг болгон ажиллах.	1-4 р улирал	ИТА, албан хаагчид
2.5 Төсөв, санхүү, эдийн засаг, дотоод гадаадын хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах.							
2.5.1	Төсвийн төлөвлөгөө боловсруулж батлуулан үйл ажиллагаа явуулах.	630,0 сая төгрөг	2022 оны санхүүгийн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулах.	2021 оны батлагдсан төсвийн дагуу үйл ажиллагаа явуулсан. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу 21.9 төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил гүйлгээ, бичиг хэрэг, шатахуун, сэлбэгийн зардалд зарцуулсан ба цалингийн зардалд 125,7 сая төгрөг, бусад зардалд 182,8 сая төгрөгийг тус тус зарцуулсан. Нийт үйл ажиллагааны зардалд 308,5 сая төгрөг зарцуулсан.	2022 оны санхүүгийн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явагдсан байна.	1-4 р улирал	Нягтлан бодогч
2.5.2	Газрын санхүүгийн тайланг олон улсын стандартад нийцүүлэн гаргаж аудитын дүгнэлтээр баталгаажуулж холбогдох байгууллагуудад хүргүүлэх	0,6 сая төгрөг	Санхүүгийн тайланг цаг хугацаанд нь гаргаж баталгаажуулах	2020 оны жилийн эцсийн тайлан ЦЭСБ аудит ХХК-иар баталгаажуулан төрийн аудитын газраас зөрчилгүй санал дүгнэлттэй. Холбогдох газруудад санхүүгийн мэдээ тайланг цаг хугацаанд нь гарган хүргүүлсэн.	Санхүүгийн тайланг цаг хугацаанд нь гаргаж аудитаар баталгаажуулан холбогдох газруудад хүргүүлэх.	1-р улирал	Нягтлан бодогч
2.5.3	Татвар, ноогдол ашгийн өглөгийг бууруулж, хяналтын зардлын авлагыг бууруулах.		Татвар, ноогдол ашгийн өглөгийг бууруулж, хяналтын зардлын авлагыг бууруулах.	2021 онд борлуулалтын орлого нь 410,1 сая төгрөг буюу 110%-иар төлөвлөгөөг давуулан бүрдүүлсэн ба үйл ажиллагааны зардалд 308,5 сая төгрөгийг зарцуулсан. Нийт 13,7 сая төгрөгийн өрийг барагдуулан, аймгийн төсөвт цэвэр ашгийн 25% иар буюу 8,0 сая төгрөгийн ноогдол ашгийг аймагт төвлөрүүлсэн.	Татвар, ноогдол ашгийн өглөгийг бууруулж, хяналтын зардлын авлагыг бууруулан ажилласан байна.	1-4 р улирал	Нягтлан бодогч

2.5.4	Бараа материалын болон үндсэн хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж хагас, бүтэн жилээр тооллого зохион байгуулах		Тооллого зохион байгуулах	Газрын 2021 оны санхүүгийн төсөв, төлөвлөгөөний дагуу бараа материал, шатахууны талон худалдан авч анхан шатны баримтыг үндэслэн орлогод аван шаардах хуудас болон шатахуун олгох хуудсыг үндэслэн ажилтнуудад олгосон. Хагас болон бүтэн жилээр тооллого зохион байгуулсан. Мөн Дархан-Уул аймгийн Засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 01-А/163 тоот захирамжаар 7 төрлийн 4,163,632 төгрөгийн өртөгтэй үндсэн хөрөнгийг актлах шийдвэр гарсны дагуу актлаж данснаас хассан. Жилийн эцсийн тооллогоор 69,690,407.95 төгрөгийн үндсэн хөрөнгө тоологдсон.	Хагас бүтэн жилээр тооллого зохион байгуулагдсан байна.	2, 4 улирал	нярав
2.6 Хууль тогтоомж, бодлого хөтөлбөр, төсөл засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дотоод аудит хийх, эрсдлийн удирдлагаар хангах.							
2.6.1	Хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, төсөл, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах		ИТА, албан хаагчдын ажлын биелэлтэд хяналт шинжилгээ хийх.	Улсын комиссоор ашиглалтад оруулсан барилга байгууламжуудад гарсан зөрчлийг ашиглагч байгууллагуудаас ирсэн гомдол, саналыг үндэслэж гүйцэтгэгч байгууллагуудаар баталгаат хугацаанд нь засварлуулах ажлыг хяналт гүйцэтгэж байсан инженерүүдээр хариуцуулан гүйцэтгүүлж байна. Жишээ нь: Багийн төвүүдийн барилга, Жинсийн орой ХХК-ийн Цэцэрлэгийн барилга /150 ор/ угсралтын ажил, Пи си эф ХХК ийн гүйцэтгэсэн замын ажил, Цахимбар инженеринг ХХК-ийн гүйцэтгэсэн замын ажил гэх мэт. Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газраас 2021 онд газрын 2019, 2020 оны үйл ажиллагаа, үр дүнд аудитын шалгалт хийсэн ба аудитаар илэрсэн барилга угсралтын зөрчил дутагдлуудыг арилгуулах арга хэмжээ авсан. Мөн аудитын актаар тогтоосон төлбөр болох 1,711,689 төгрөгийг хугацаанд нь төлж барагдуулсан.	Хэрэгжих төслүүдийг чанарын өндөр түвшинд гүйцэтгүүлж, ажлын биелэлтэд үнэлгээ дүгнэлт өгөх.	1-4 улирал	Газрын удирдлага

2.6.2	Газрын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг боловсруулан батлуулж холбогдох байгууллагуудад цаг хугацаанд нь хүргүүлэх.		Үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөөг хүргүүлэх.	2020 оны газрын үйл ажиллагааны тайлан, 2021 оны эхний хагас жил, жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг холбогдох аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-т хугацаанд нь хүргүүлсэн ба 2021 оны 02-р дугаар сард аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал, ИТХ-ын төлөөлөгчдөд 2020 онд хэрэгжүүлсэн ажлын тайланг танилцуулсан. Газрын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан аймгийн Засаг даргаар батлуулан үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан. Инженер техникийн ажилтан, албан хаагчид нь 2021 онд захиалагчийн техникийн өдөр тутмын болон үе шатны хяналт хэрэгжүүлсэн объект тус бүрээр тайланг гарган газрын мэдээллийн санг үүсгэн ажилласан ба эхний хагас жил, бүтэн жилийн тайланг Аймгийн ЗДТГ ын ХОХБТХ-т хүргүүлсэн.	Төлөвлөгөө, тайланг аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ, ТЗУХ-т цаг хугацаанд нь хүргүүлэх.	1-4 улирал	Ерөнхий инженер, Бичиг хэрэг
-------	--	--	--	--	--	------------	------------------------------